

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 03
дугаар сарын 23-ны өдрийн 145 дугаар тогтоолоор
батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-ийн
хавсралт 1

Тэнгэрлиг Медиа Групп ХК

Компанийн засаглалын үйл ажиллагааны тайлангийн маягт						
		<p>“Компанийн засаглалын кодекс”-ийн зарчмын зүйл тус бүрээр үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайланг дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэнэ.</p> <p><i>Кодексийн хэрэгжилтийг “Хэрэгжүүл, эсвэл тайлбарла” гэсэн зарчмын дагуу тайлагнах ба кодексийн зүйл тус бүрээр биелүүлсэн эсэх, биелүүлээгүй бол яагаад биелүүлээгүй, түүнийг орлох бүтэц, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, эсхүл авч байгаа, хэрэв төлөвлөж буй бол хугацаатайгаар нь тайлбар хэсэгт тусгана..</i></p>				
		<p>НЭГ. ТУЗ-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна</p>				
№	Зүйл	Хэрэгжилт	Тайлбар 1	Тайлбар 2	Оноо	Хувь
1	<i>1.1. Компани нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.</i>	ТУЗ-ийн 2021 оны 8 сарын 6-ны өдрийн 21/28 тоот тогтоолын нэгдүгээр хавсралтаар ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг баталж, хэрэгжүүлж байгаа			2	
2	<i>1.2. Компани нь ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримттай байна.</i>	“ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-даа ТУЗ-ийн гишүүнийг нэр дэвшүүлэх, гишүүнээр сонгох ба чөлөөлөх тухай зүйлийг багтаасан			2	
3	<i>1.3. ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, цахим хуудсандаа байршуулна.</i>	Жилийн үйл ажиллагааны тайлангийн компанийн засаглалтай холбоотой мэдээлэлдээ ТУЗ-ийн гишүүдийн нэрс, хэдэн удаа хуралдсан зэрэг мэдээллийг оруулсан			2	

4	1.4. Компани нь ТУЗ болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримттай байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэрт байдал зэргийг тусгана.	ТУЗ-ийн 2021 оны 8 сарын 6-ны өдрийн 21/30 тоот тогтоолын нэгдүгээр хавсралтаар аудитын хорооны журам; 21/31 тоот тогтоолын нэгдүгээр хавсралтаар засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны журам, 21/32 тоот тогтоолын нэгдүгээр хавсралтаар хөрөнгө оруулалт, санхүү, эрсдэлийн хорооны журмыг тус тус батлан хэрэгжүүлж байгаа. Журам бүрд хорооны гишүүдийг сонгох, чөлөөлөх тухай тусгасан			2	
5	1.5. ТУЗ-ийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, тэдгээрийг шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.	ТУЗ-ийн гишүүд хурлаар журмуудыг хэлэлцэн баталсан	ТУЗ-ийн гишүүд өөрчлөгдөхөөр болвол Үйл ажиллагааны журам, хороонд томилогдсон бол тус хорооны журмыг танилцуулж ажиллах болно		2	
6	1.6. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар ТУЗ-ийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.	Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн даргатай байнгын холбоотой ажилладаг			2	
ДҮН					12	100%
ХОЁР. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ						
7	2.1. ТУЗ-ийн дарга болоод ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.	Төлөөлийн удирдах зөвлөлийн гишүүдийн гуравны нэг нь хараат бус гишүүд, ТУЗ-ийн дарга ердийн гишүүн			2	
8	2.2. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.	ТУЗ-ийн 2021 оны 8 сарын 6-ны өдрийн 21/30 тоот тогтоолын нэгдүгээр хавсралтаар аудитын хорооны журмыг батлан хэрэгжүүлж байгаа. Аудитын хорооны даргаар хараат бус гишүүн томилогдон ажилладаг			2	

9	2.3. ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцоно.	ТУЗ-ийн 2021 оны 8 сарын 6-ны өдрийн 21/31 тоот тогтоолын нэгдүгээр хавсралтаар засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны журмыг батлан хэрэгжүүлж байгаа. Тус хорооны даргаар хараат бус гишүүн томилогдон ажилладаг			2	
10	2.4. ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.	ТУЗ-ийн 2021 оны 8 сарын 6-ны өдрийн 21/31 тоот тогтоолын нэгдүгээр хавсралтаар засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны журмыг батлан хэрэгжүүлж байгаа. Тус хорооны даргаар хараат бус гишүүн томилогдон ажилладаг			2	
11	2.5. ТУЗ нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. ТУЗ-ийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршилага бүхий бүрэлдэхүүнтэй байна.	ТУЗ нь өөрийн дэргэд аудит; засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшуулал; хөрөнгө оруулалт, санхүү эрсдэлийн хороотой. Хороод тус бүр дагаж мөрдөх журамтай			2	
ДҮН					10	100%
ГУРАВ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ ТУЗ нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана						
12	3.1. ТУЗ нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	ТУЗ-ийн 2021 оны 8 сарын 6-ны өдрийн 21/3. тоот тогтоолын нэгдүгээр хавсралтаар мэдээллийн ил тод, нээлттэй байдлын журмыг баталж, хэрэгжүүлж байгаа.			2	
13	3.2. ТУЗ нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.	Компанийн цахим хуудсанд дүрэм журмуудыг байршуулсан			2	

14	3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.	Санхүүгийн тайланг олон улсын стандартын дагуу гарган, хөндлөнгийн аудитаар баталгаажуулан цахим хуудаснаа байршуулсан			2	
ДҮН					6	100%
ДӨРӨВ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО ТУЗ нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана						
15	4.1. ТУЗ нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, түүнийг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	ТУЗ-ийн 2021 оны 8 сарын 6-ны өдрийн 21/26 тоот тогтоолын нэгдүгээр хавсралтаар хөндлөнгийн аудит томилох журмыг баталж, хэрэгжүүлж байгаа			2	
16	4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.		2021 оны хувьцаа эзэмшигчдийн хуралд хөндлөнгийн аудитор оролцоогүй, дараагийн жилүүдээс хөндлөнгийн аудиторыг хуралд оролцуулж байх болно	2022 оны хувьцаа эзэмшигчдийн хуралд “Хүлэгт хүннү аудит” ХХК-ийн Гүйцэтгэх захирал И.Гүррагчаа оролцож ХЭ-дэд мэдээлэл өгсөн	2	
17	4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, тэдгээрт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар олон нийтэд тухай бүр мэдээлнэ.		Дотоод аудитын журмыг хэлэлцэн баталж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх болно	ТУЗ-ийн 2022 оны 10 сарын 26-ны өдрийн 22/10 тоот тогтоолын нэгдүгээр хавсралтаар тус журмыг баталсан	1	
ДҮН					5	83.3%

ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА
ТУЗ нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой
байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд
ТОГТМОЛ ХЯНАЛТ ТАВИНА

18	5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.	ТУЗ-ийн 2021 оны 8 сарын 6-ны өдрийн 21/27 тоот тогтоолын нэгдүгээр хавсралтаар эрсдэлийн удирдлагын журмыг баталж, хэрэгжүүлж байгаа			2	
19	5.2. ТУЗ нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана.	ТУЗ нь дэргэдээ хөрөнгө оруулалт, санхүү, эрсдэлийн хороотой бөгөөд, 4 гишүүдтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг. Хорооны даргаар ердийн гишүүн томилогдон ажилладаг.	Ээлжит ТУЗ-ийн хурлаар хорооны даргаар хараат бус гишүүнийг томилох болно	ТУЗ-ийн 2023 оны 3 сарын 17-ны өдрийн 23/04 тоот тогтоолоор хараат бус гишүүн В.Ганзоригийг хороон даргаар томилсон	2	
20	5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.	Компани нь медиа салбарт үйл ажиллагаа явуулдаг бөгөөд хөдөлмөрийн хөнгөн нөхцөлд хамаардаг			2	
21	5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.		Ээлжит ТУЗ-ийн хурлаар комплайнсын хяналтын журмыг хэлэлцэн батлах болно	ТУЗ-ийн 2022 оны 10 сарын 26-ны өдрийн 22/10 тоот тогтоолын Хоёрдугаар хавсралтаар баталсан	1	
ДҮН					7	87.5%

		ЗУРГАА. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна				
22	6.1. ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.	Компанийн ашигт ажиллагаа тодорхой дүнд хүрсний дараа ТУЗ-ийн гишүүдэд цалин урамшуулал олгохоор компанийн зүгээс санал гаргасан.	Ашигт ажиллагаанд хүрэх үед ХЭ-ийн ээлжит/ээлжит бус хурлаар цалин урамшуулал, олгох хэлбэр, давтамжийг хэлэлцэж батлах болно	2023 оны 4 сарын 28-ны өдрийн ХЭ-ийн хурлаар ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг хэлэлцэж баталсан	1	
23	6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримтад тусгана.		Ээлжит ТУЗ-ийн хурлаар цалин урамшууллын журамд эдгээр зүйл шалгууруудыг нэмж тусган батлах болно	ТУЗ-ийн 2023 оны 5 сарын 1-ний өдрийн 23/06 тоот тогтоолын гуравдугаар хавсралтаар Цалин урамшууллын бодлогыг баталсан	1	
24	6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.	Гүйцэтгэх удирдлагад олгосон нийт цалинг 2021 оны үйл ажиллагааны тайланд тусгасан. Компанийн ашиг орлоготой уялдуулан гүйцэтгэлийн шалгуурыг гаргасан			2	
ДҮН					4	66.7%
		ДОЛОО. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ				
25	7.1. Компани нь ТУЗ-өөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.		Ээлжит ТУЗ-ийн хурлаар бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлогын баримт бичгийг хэлэлцэн батлах болно	ТУЗ-ийн 2023 оны 5 сарын 1-ний өдрийн 23/06 тоот тогтоолын тавдугаар хавсралтаар оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлогыг баталсан	1	
26	7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.		2021 оны жилийн үйл ажиллагааны тайланд энэ талаар тусгаж өгөөгүй, 2022 онд үйл ажиллагааны тайландаа тусгаж өгөх болно	Оролцогч талуудтай хамтран ажиллах бодлогыг 2023 онд баталсан бөгөөд 2023 оны жилийн үйл ажиллагааны тайланд тус мэдээллийг тусгаж ажиллах болно	1	

27	7.3. <i>Оролцогч талуудтай амтран ажиллах, солилцох, зорилгоор цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.</i>	Цахим хуудсанд компанитай холбогдох сошиал хаягуудын холбоос болон цахим шууданг холбосон байдаг бөгөөд оролцогч талууд хэзээд бидэнтэй холбогдоход нээлттэй			2	
28	7.4. <i>Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.</i>	Компани нь дотоод журамтай бөгөөд уг журмын дагуу ажилтнуудын санал хүсэлт зэргийг зохицуулж явдаг			2	
ДҮН					6	75%
		НАЙМ. КОМПАНИЙН СОЁЛ ТУЗ-ийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно				
29	8.1. <i>Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор ТУЗ нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</i>	Компани үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж үүнийхээ дагуу ажиллаж буй. ТУЗ-ийн 2021 оны 8 сарын 6-ны өдрийн 21/33 тоот тогтоолын нэгдүгээр хавсралтаар ТУЗ-ийн ёс зүйн кодексийг баталж, хэрэгжүүлж байгаа.			2	
30	8.2. <i>Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг ТУЗ, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх “шүгэл үлээгчийн” тогтолцоотой байна.</i>	ТУЗ-ийн ёс зүйн кодексет ёс зүйн зөрчлийг тайлагнах талаар тусгасан.	Уг журманд мэдээлэл өгсөн этгээд буюу “шүгэл үлээгч”-ийн нууцлалыг хадгалах, түүний нэр хүнд, цалин урамшуулал, ажлын байрыг нь хамгаалах зохицуулалтыг ээлжит ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн нэмж тусгах болно.	ТУЗ-ийн 2022 оны 10 сарын 26-ны өдрийн 22/10 тоот тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар ТУЗ-ийн ёс зүйн кодексийн журамд нэмж оруулан баталсан	2	

31	8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.		Ээлжит ТУЗ-ийн хурлаар ёс зүйн дүрэмд эдгээр зүйл заалтуудыг нэмж тусган батлах болно	ТУЗ-ийн 2022 оны 10 сарын 26-ны өдрийн 22/10 тоот тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар нэмж баталсан	1	
ДҮН					5	83.3%
ЕС. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана						
32	9.1. Компани оролцогч талуудад өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын бүтэц, зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа тухай бүр хүргэнэ.	Компани цахим хуудсаар дамжуулан үйл ажиллагаа, санхүүгийн байдал, тайлан, засаглалын талаарх мэдээллийг тухай бүр мэдээллэж байгаа.			2	
33	9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба тэдэнтэй харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.	Компанийн цахим хуудас дээр компанитай холбогдох боломжит социал хаягууд, цахим шуудан, санал хүсэлтийн хэсгийг холбосон	Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөрийг боловсруулан ээлжит ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн батална	ТУЗ-ийн 2023 оны 5 сарын 1-ний өдрийн 23/06 тоот тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар баталсан	2	
34	9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.	ТУЗ-ийн 2021 оны 8 сарын 6-ны өдрийн 21/24 тоот тогтоолын нэгдүгээр хавсралтаар ХЭ-ийн хурлыг зарлан хуралдуулах журмыг баталж, хэрэгжүүлж байгаа			2	
35	9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтцийн асуудлаар хувьцаа эзэмшигчдээс санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.		ТУЗ нь шинээр хөрөнгө татан төвлөрүүлэх, үнэт цаас нэмж гаргахаар болбол ХЭ-ийн одоогийн эзэмшиж буй хувийг бууруулахгүй, хувь тэнцүүлэн худалдан авах боломжийг олгон ажиллах болно		2	
36	9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх	ТУЗ-ийн 2021 оны 8 сарын 6-ны өдрийн 21/25 тоот тогтоолын нэгдүгээр хавсралтаар ашиг			2	

	<p>зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.</p>	<p>сонирхлын зөрчлийг зохицуулах журмыг баталж, хэрэгжүүлж байгаа</p>				
ДҮН				10	100%	
НЭГДСЭН ДҮН				65	90.3%	
		<p><i>Санамж:</i></p> <p><i>Компани нь засаглалын зарчмуудыг Монгол Улсын үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад үнэт цаасаа бүртгүүлсэн бүх хуулийн этгээд хэрэгжүүлнэ.</i></p> <p><i>Тухайлбал, “МХБ” ХК-ийн 1-р ангилалд бүртгэлтэй үнэт цаас гаргагч нь кодексийн зүйл тус бүрээр энэхүү маягтын дагуу хэрэгжилт, эсхүл тайлбарыг бүрэн, 2-р ангилалд бүртгэлтэй этгээд 95 хувийг хангасан байна.</i></p> <p><i>Хэрэв дээр дурдсан шалгуурыг хангаагүй буюу хэрэгжүүлээгүй эсвэл тайлбарлаагүй тохиолдолд Тухайн ХК-ийн МХБ-ийн бүртгэлийн ангиллыг бууруулах үндэслэл болох ба нөгөө талаас хөрөнгө оруулагч шийдвэр гаргахад нөлөөлөх шалтгаан болно.</i></p>				